

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ аймгийн Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/020/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИН ТАНАА

2026-03-12 № 2026/020/НА-СТА-ОНӨЧТ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь тайлант онд 26,926.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,545.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авч бүртгэл тайланд тусгасан байна. Мөн аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай 49 дүгээр тогтоолоор 2,199.7 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн, 50 дугаар тогтоолоор 12,166.7 мянган төгрөгийн үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тавилга, тоног төхөөрөмж болон автомашиныг акталж үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4326050306

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус газар нь тайлант оны орлого, зарлагыг тус бүр 281,141.0 мянган төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 354,419.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн, 294,536.1 мянган төгрөгийн зардал гаргаж, 59,883.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг аймгийн Засаг даргаар хянуулж, гүйцэтгэлийг үнэлүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	480,767,014.62	204,055,129.74
1.1.2	Дансны авлага	52,586,403.48	208,739,917.48
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	(0.00)	16,461,736.96
1.1.4	Бусад авлага	0.00	132,627,241.00
1.1.6	Бараа материал	2,510,100.03	2,722,080.07
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	535,863,518.13	564,606,105.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,890,956.11	48,908,235.59
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	28,890,956.11	48,908,235.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	564,754,474.23	613,514,340.84
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	0.01	(0.01)
2.1.1.3	Татварын өр	23,213,131.46	12,171,771.97
2.1.1.4	НДШ - ийн өглөг	82,499.68	(0.00)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	23,295,631.15	12,171,771.96
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,295,631.15	12,171,771.96
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	541,458,843.09	601,342,568.88
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	541,458,843.09	601,342,568.88
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	564,754,474.23	613,514,340.84

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	263,157,783.91	346,980,021.82
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	263,157,783.91	346,980,021.82
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	6,776,417.75
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	663,403.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	118,999,331.81	285,484,793.57
11	Санхүүгийн зардал	0.00	677,641.78
12	Бусад зардал	1,185,700.00	1,224,309.09
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	495,625.03
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	142,972,752.10	66,537,473.09
19	Орлогын татварын зардал	1,429,727.52	6,653,747.30
20	Татварын дараах ашиг (алдагдал)	141,543,024.58	59,883,725.79
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	141,543,024.58	59,883,725.79
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00

	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	141,543,024.58	59,883,725.79
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	399,915,818.51	399,915,818.51
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	146,722,089.99	146,722,089.99
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	(5,179,065.41)	(5,179,065.41)
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	541,458,843.09	541,458,843.09
10	Тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	59,883,725.79	59,883,725.79
14	Тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00

18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
19	Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
20	2025 оны 3-р сарын 10- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	601,342,568.88	601,342,568.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	242,759,787.00	226,187,913.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	242,759,787.00	226,187,913.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	242,759,787.00	225,524,510.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	663,403.00
1.2	Мөнгөн зарлага (-)	128,612,343.48	475,025,215.63
1.2.1	Ажиллагчдад төлсөн	70,616,818.00	162,544,924.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	19,468,540.90	46,801,563.60
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,461,240.00	9,743,922.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,301,800.00	7,920,139.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,696,900.00	21,465,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	18,539,204.58	81,766,887.73
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	96,250.00	49,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,431,590.00	144,733,278.80
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	114,147,443.52	(248,837,302.63)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	13,552,835.50
2.1.1	Хүлээн авсан хүүний орлого	0.00	13,552,835.50
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,047,900.00	34,619,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,047,900.00	34,619,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,047,900.00	(21,066,164.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	(269,903,467.13)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,398,383.35	480,767,014.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,398,383.35	204,055,129.74

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төсөв /төгрөгөөр/	Гүйцэтгэл /төгрөгөөр/	Зөрүү	Хувь
1	Нийт орлого /НӨАТ-гүй/	281,141.0	354,419.8	(73,278.8)	126.1
2	Нийт зарлагын дүн	281,141.0	294,536.1	(13,395.1)	104.8
3	Цалин хөлс	158,442.0	211,376.4	(52,934.4)	133.4
	Үндсэн цалин	128,042.0	162,544.9	(34,502.9)	126.9
	Урамшуулал	8,000.0	2,030.0	5,970.0	25.4
	НДШ-ийн зардал	22,400.0	46,801.5	(24,401.5)	208.9
4	Бараа үйлчилгээний бусад зардал	38,614.0	28,544.1	10,069.9	73.9
	Түлш шатахуун	13,514.0	10,800.0	2,714.0	79.9
	Бичиг хэрэг	5,000.0	2,760.4	2,239.6	55.2

	Шуудан холбоо	800.0	417.0	383.0	52.1
	Нэг удаагийн тэтгэмж	500.0	-	500.0	0.0
	Түрээсийн зардал	1,500.0	3,420.1	(1,920.1)	228.0
	Даатгалын зардал	200.0	49.5	150.5	24.8
	Тээврийн хэрэгслийн татвар	100.0	94.7	5.3	94.7
	Аймгийн ЗДТГ-т гэрээний дагуу	14,000.0	10,324.7	3,675.3	73.7
	Үйл ажиллагааны бусад зардал	3,000.0	677.6	2,322.4	22.6
Өөрсдийн хөрөнгөөр					
5	Өөрийн хөрөнгө	84,085.0	54,615.7	29,469.4	65.0
	Үйл ажиллагааны бусад зардал	5,000.0	3,790.7	1,209.4	75.8
	Хяналтын ажил хийхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж	28,015.0	34,619.0	(6,604.0)	123.6
	Программ хангамжийн зардал	14,370.0	693.0	13,677.0	4.8
	Сэлбэг хэрэгсэл	3,500.0	3,465.0	35.0	99.0
	Албан томилолт	11,000.0	8,900.0	2,100.0	80.9
	Аудитын төлбөрт	1,200.0	588.0	612.0	49.0
	Сургалт	6,000.0	1,330.0	4,670.0	22.2
	Албан өрөөний засвар хийх	15,000.0	1,230.0	13,770.0	8.2
6	Нийт ажиллагсдын тоо	12	7	5	58.3
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	5	3	2	60.0
	ИТА	6	3	3	50.0

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь тайлант жилд “Барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, инженерийн дэд бүтцийн ажил зэрэг төслүүдийг хууль, стандарт, норм дүрмийн дагуу чанартай, аюулгүй гүйцэтгэлтэй эсэхэд хяналт тавих замаар иргэдийн амьдрах орчны аюулгүй, тав тухтай байдлыг хангах” гэсэн зорилго тавьж, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд “иргэдийн амьдрах орчин, аюулгүй байдлыг хамгаалахуйц чанартай бүтээн байгуулалтыг хянан баталгаажуулах” гэсэн зорилгыг тавьж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2021 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,759.9 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	480,767.0	204,055.1	-276,711.9
Авлага	52,586.4	357,828.9	305,242.5
Бараа материал	2,510.1	2,722.1	212.0
Үндсэн хөрөнгө	28,891.0	48,908.2	20,017.3
Нийт хөрөнгийн дүн	564,754.5	613,514.34	48,759.9
Өр төлбөр	23,295.6	12,171.8	-11,123.9
Эздийн өмч	541,458.8	601,342.6	59,883.7

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	564,754.5	613,514.3	48,759.9
--	-----------	-----------	----------

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 276,711.9 мянган төгрөгөөр буурсан нь 354,419.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 294,536.1 мянган төгрөгийг зарцуулсан болон тайлант жилийн авлага өссөнтэй холбоотой байна.

Дансны авлага 357,828.9 мянган төгрөг болж 305,242.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аймаг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын 313,944.4 мянган төгрөгийн 66 ажил, аймаг, сумын ОНХС-ийн 175,501.4 мянган төгрөгийн 44 ажил, замын сангийн 21,540.3 мянган төгрөгийн 8 ажил зэрэг нийт 510,986.1 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын орлого орж ирэхээс 187,295.5 мянган төгрөгийн орлого орж 323,690.6 мянган төгрөгийн авлага үүссэн. Мөн өмнөх оноос шилжсэн 17,676.5 мянган төгрөг, татварын 16,461.7 мянган төгрөгийн авлага үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,722.1 мянган төгрөг байгаа нь байгууллагын хөрөнгөөр 17,152.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 16,940.4 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 48,908.2 мянган төгрөг болж өмнөх оноос 20,017.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 26,926.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,545.4 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан, аймгийн ИТХ-ын 49 дүгээр тогтоолоор 2,199.7 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг балансаас баланст шилжүүлсэн, 50 дугаар тогтоолоор 12,166.7 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, автомашин зэргийг акталж бүртгэлээс хассан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,171.8 мянган төгрөг болж 11,123.9 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөг 3,191.3 мянган төгрөгөөр, НӨАТ-ын өглөг 6,420.3 мянган төгрөгөөр, НДШ-ийн өглөг 82.5 мянган төгрөгөөр, ААНОАТ-ын өглөг 1,429.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Программ хангамжийн зардалд 14,70.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас санхүүгийн программын төлбөрт 693.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/21 дүгээр захирамжаар тус байгууллагын 2025 оны орлогын төлөвлөгөөг үйл ажиллагааны орлогоос 197,056.0 мянган төгрөг, өмнөх оны мөнгөн хөрөнгийн

үлдэгдлээс 84,085.0 мянган төгрөг, нийт 281,141.0 мянган төгрөгөөр, зарлагын төлөвлөгөөг мөн адил 281,141.0 мянган төгрөг байхаар баталсан байна.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны орлогоос 354,419.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 294,536.1 мянган төгрөгийн зардал гарган 59,883.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай гэж тайлагнасан байна.

Тайлант онд 281,141.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 354,419.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн 73,278.8 мянган төгрөг төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 294,536.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 13,395.1 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар хэтэрсэн нь НДШ-ийн зардал, түрээсийн зардал болон багаж, тоног төхөөрөмжийн зардлууд хэтэрснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар хоолны хөнгөлөлтийг өдрийн 12.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд 15,684.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар захирамжаар бүтэц, орон тоог батлахдаа тус газрыг 12 албан хаагчтай байхаар орон тоо баталснаас тайлант онд 7 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж, сул орон тоонд нөхөн томилгоо хийгдээгүй,
- Тайлант онд сургалтын зардалд 6,000.0 мянган төгрөг төлөвлөж баталснаас гүйцэтгэлээр 1,330.0 мянган төгрөг зарцуулсан,
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гаргаагүй,
- Гадаад томилолтоор ажиллаагүй, хэвлэл, мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал,

аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 263,157.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,631.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 28 төрлийн 182 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сонин, хэвлэл, сэтгүүлийн захиалга хийгээгүй,
- Цалин хөлсний зардлыг хэмнэж ажилласан
- Засварын зардлыг хэмнэсэн
- Шинэ жил болон бусад баяр ёслолд зардал гаргалгүйгээр зардлуудыг хэмнэсэн зэргээр гэх мэт.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 432 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан, хаана, хэзээ ажилласныг тодорхойлох гарын үсэг зэргээр томилолтын хуудсыг баталгаажуулалгүйгээр томилолтын зардал, жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахууны зардал гаргасан зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс, жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахууны зардал гаргасан зөрчлийг давтан гаргалгүй хэрэгжүүлж ажилласан, гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан, хаана, хэзээ ажилласныг тодорхойлох гарын үсэг зэргээр томилолтын хуудсыг баталгаажуулалгүйгээр томилолтын зардал гаргасан зөрчлийг давтан гаргасан тул өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 50.0 хувиар тооцлоо.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	0.0	1	0.0	50.0
Нийт дүн	2	0.0	1	0.0	50.0

Гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан, хаана, хэзээ ажилласныг тодорхойлох гарын үсэг зэргээр томилолтын хуудсыг баталгаажуулалгүйгээр томилолтын зардал гаргасан зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасны дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 1,480.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1 албан шаардлага өгөгдлөө.

5.1 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй даргын гарын үсэг, гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан, томилолтын ажлын үр дүнг хянаж хаагаагүй зэрэг томилолтын хуудсыг баталгаажуулалгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 1,480.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Хүчин төгөлдөр бус баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*”, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*” журмын 4.2.1.10-т “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн	1	1,480.0			1	1,480.0						
Дүн	1	1,480.0			1	1,480.0						